



Насан туршийн боловсрол

Насан туршийн боловсролын үзэл санаа (1)



- ▶ 1919 онд Их Британи насанд хүрэгчдийн хорооны тайланд: Насанд хүрэгчдийн боловсрол хөгжсөнтэй холбогдож боловсрол нь бүх нийтийн насан туршийн үйл хэрэг байна гэж бичжээ.
- ▶ 1929 онд Basil Yeaxlee /1883-1967/: Насан туршийн боловсролын анхны ойлголтыг тодорхойлж, номыг бичсэн.
 - ▶ Насанд хүрэгчдийн боловсрол хөгжих болсонтой холбогдон боловсролыг насан туршдаа эзэмших, насан туршдаа суралцах, боловсрол насан туршийн үйл явц гэсэн ойлголт, үзэл баримтлал бий болжээ.
- ▶ 1970 онд ЮНЕСКО насан туршийн боловсрол гэсэн ойлголтыг гол үзэл баримтлал болгон хэрэглэж эхэлжээ.



Насан туршийн боловсролын үзэл санаа (2)



Тасралтгүй боловсрол

Насанд хүрсэн хүний өмнөх боловсролоос үл хамааран мэргэжил дээшлүүлэх, мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэх, шинэчлэх зорилгоор их дээд сургууль, сургалтын байгууллагын явуулж буй богино хугацааны сургалтад хамрагдах үйл явц юм.



Насан туршдаа суралцахуй

Ажил эрхлэх, хувь хүний зорилгоо биелүүлэхээр мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх үүднээс хүн амьдралынхаа туршид албан бус хэв маягаар суралцах боломжийг бий болгох буюу хангах үйл явц юм.



Насан туршдаа суралцах нь иргэн таньд ямар хэрэгтэй вэ?

- ▶ Өөрийн амьдралын чанарыг дээшлүүлэх
 - ▶ Сайхан амьдрах
 - ▶ Нийгмийн амьдралд оролцох
 - ▶ Улс эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах
-



Насан туршдаа суралцах арга зам




- ▶ Дэлхийн нийтээр “Насан туршийн боловсрол” гэдэг нь төрөхөөс насан хутгийг олох хүртэл сурч боловсрох гэсэн үзэл санааг ойлгож байгаа бөгөөд хүмүүнлэг ардчиллын үнэт зүйл болон тэгш хамруулах зарчимд тулгуурласан, боловсролын бүх хэлбэрийг хамарсан, мэдлэгт суурилсан нийгмийн салшгүй хэсэг гэж тодорхойлон үзэж байна
- ▶ Насан туршдаа тасралтгүй суралцахыг дэмжин хөгжүүлэх нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын чухал нэг хэсэг бөгөөд энэ нь иргэдийн нийгэм дэх оролцоо, идэвхтэй иргэн, нийгэмд өрсөлдөх чадвар, ажил эрхлэлт ба хувь хүний хөгжилд онцгой ач холбогдолтой билээ.



ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ▶ Насан туршийн боловсролын төв нь сургууль завсардсан хүүхэд, бичиг үсэггүй иргэдэд бичиг үсгийн анхан шатны боловсрол олгох бага, суурь боловсролыг дүйцсэн хөтөлбөрөөр нөхөн олгодог.



- ▶ 1997 онд Монгол улсын Засгийн газрын 116 дугаар тогтоолоор баталсан “Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т 6 үндсэн зорилт дэвшүүлсний нэг нь сургуулийн гадна буй болон сургууль завсардсан хүүхэд, залууст **боловсрол нөхөн олгох** чиглэл байсан юм. Энэ нь ямар нэгэн шалтгаанаар сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаж байгаагүй хүүхэд, залууст ерөнхий боловсрол нөхөн эзэмших хоёр дахь боломж олгож, ерөнхий боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй болгох, Боловсролын тухай хуулийн “*бүх нийтээр суурь боловсролыг заавал эзэмших*” тухай заалтыг хэрэгжүүлэхэд мөн Дэлхий нийтийн томоохон зорилтууд болох Мянганы хөгжлийн зорилт, Дакарын үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ - Бүх нийтийн боловсролын зорилт, “Бичигтэн” болох НҮБ-ын 10 жил болон Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жилийн хүрээнд тулгарч буй нэгдмэл нэг **зорилт** бол “*хүн амынхаа бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар амьдрах, аж төрөх ухаанд сургах, амьдралын чанарыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй амьдралын зөв зан үйлийг төлөвшүүлэхэд* НТБ дүйцсэн хөтөлбөрийн сургалт чухал үүрэг гүйцэтгэхийг нотолсон билээ.

Мөн бүх насны иргэдэд насан туршийн боловсролын 5 чиглэлээр сургалт үйл ажиллагаа зохион байгуулдаг.



Гэр бүлийн
боловсрол



Иргэний
боловсрол



Ёс суртахууны
боловсрол



Гоо зүйн
боловсрол



Амьдрах ухааны
боловсрол





Амьдрах ухааны
ур чадвар



Амжиргааны
ухааны ур чадвар





Анхаарлаа хандуулсанд баярлалаа